



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

Азийн Хөгжлийн Банк



Сургуулийн урсгал засвар болон бусад үйл
ажиллагааны зардлыг санхүүжүүлэх

Боловсролын багц тусламж

*“Санхүүгийн хямралын үед эмзэг бүлгийн иргэдэд боловсролын
үйлчилгээ хүргэх” төслөөс санхүүжүүлэв*

Гарын авлага 2010/11

Ховд, Дорнод, Хөвсгөл аймгийн төрийн өмчит бүх сургуулийг хамарна

2010 оны 8 сарын 17

© **БСШУЯ**, 2010

416 тоот, Соёлын төв өргөө (Г Байр)
Ерөнхий сайд Амарын гудамж,
Бага тойрог – 44, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар хот – 14300
Монгол Улс

Вэб хуудас: www.mecs.gov.mn
Утас: +976(51) 260657, +976(11)70117109 / 7011716
Email : enkhee@mecs.gov.mn or bayarmaa@crisis.mn

Өмнөтгөл

Сүүлийн жилүүдэд нүүрлэсэн санхүү, эдийн засгийн хямрал нь засгийн газрын төсөвт хүндээр туссан. Боловсролын салбарын төсөв харьцангуй тогтвортой байсан хэдий ч 'хувьсах бусад зардлын' зүйл анги 2005 онд нийт төсвийн 9.7%-ийг эзэлж байсан бол 2010 онд 4.1% болтлоо буурсан. Нэн ялангуяа сургуулийн захиргаа удирдлагын зардал, сургалтын хэрэглэгдэхүүн, жижиг эд хогшил худалдан авах, урсгал засвар гэх мэт зардлын зүйл ангид багтах үйл ажиллагаа нь ихээхэн өртөж, төсөв нь танагдсан. Эдгээр зүйл ангиуд боловсролын чанар, сургалтын орчинд нөлөөлдөг учраас сэтгэл зовоох асуудлуудын нэг болов.

Засвар үйлчилгээ, жижиг эд хогшил худалдан авах зүйл ангиуд танагдсантай холбоотойгоор сүүлийн жилүүдэд эцэг эх болон бусад эх үүсвэрээс сайн дурын хандив тусламж авах замаар сургалтын орчинг сайжруулж байна. Гэсэн хэдий ч сургууль бүрт ийм арга замаар асуудлаа шийдвэрлэх боломж байхгүйгээс "Санхүүгийн хямралын үед эмзэг бүлгийн иргэдэд боловсролын үйлчилгээ хүргэх" төслийн Азийн Хөгжлийн Банкнаас санхүүжүүлэх болсон.

Багц тусламжаар сургуулийн анги танхим, коридор, дээвэр, дотуур байрны хана туургын урсгал засвар, анги танхим, дотуур байранд хэрэглэгдэх жижиг эд хогшил, сургалтын хэрэглэгдэхүүн худалдаж авах санхүүжилт хийгдэх бөгөөд сургуулиуд (сургуулийн захиргаа ба сургуулийн удирдах зөвлөл хамтран) багц тусламжийг захиран зарцуулах талаар өөрсдөө шийдвэрээ гаргаж, дээр дурьдсан зүйл ангид багтаан зарцуулалтыг хийх эрхээр хангагдана.

Багц тусламжийг хэрэгжүүлэх үйл явцад сургуулийн удирдах зөвлөл нилээдгүй үүрэг гүйцэтгэх бөгөөд тухайн сургуулийн нөхцөл байдалд нийцсэн засвар тохижилтийн төлөвлөгөөг сургуулийн захиргаа, сургуулийн удирдах зөвлөлтэй хамтран боловсруулснаар багц тусламжийг хэрэгжүүлэх зөвшөөрөл олгогдоно. Ийм зарчмаар боловсруулсан багц тусламжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хянаж, дүгнэлт өгөх үүргийг Аймгийн БСГ-ууд хүлээх бөгөөд ингэхдээ сургуулийн хийсэн сонголтыг бус гарын авлагын дүрэм журамд нийцсэн төлөвлөгөө боловсруулсан эсэхэд нь үнэлэлт өгнө.

'Хувьсах бусад зардлыг' хоёр дахин өсгөх зориулалт бүхий багц тусламжинд хамрагдах 'нэн шаардлагатай' сургуулийг тусгай аргачлалаар сонгон шалгаруулна. Багц тусламжийг хэрэгжүүлснээр хамрагдаж буй сургуулиудын сургалтын орчин сайжрах болно.

Туршилтын эхний жилд гурван аймгийн сургуулиуд хамрагдана. Харин төсөл хэрэгжих хоёрдахь жилээс (2011/2012) нийт 10 аймаг, Улаанбаатар хотын зарим дүүргийг хамруулахаар зорьж байна.

Энэ дашрамд дэлхийн санхүү, эдийн засгийн хямралаас үүдэлтэй хүндрэл бэрхшээлийг даван туулахад боловсролын багц тусламжийн хөтөлбөр хэрэгжүүлэх санхүүгийн боломж олгож буй Азийн Хөгжлийн Банкнд яамны зүгээс талархлаа илэрхийлж байна. Энэхүү ажлын хэрэгжилт оролцогч

сургуулиудын сургуулийн захиргаа, сургуулийн удирдах зөвлөл, Аймгийн БСГ зэрэг гол оролцогч талуудын идэвх чармайлтаас шалтгаалах учиртай. Иймээс багц тусламжаар олгогдож буй энэхүү боломжийг сайтар ашиглаж, үр бүтээлтэй ажиллахыг уриалахын ялдамд шаардлагатай үед яамны зүгээс туслалцаа авах боломжтойг дурьдах нь зүйтэй.

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны яам

Товьёог

1. Багц тусламжийн танилцуулга	1
1.1 Сургуулийн санхүүжилт.....	1
1.2 Багц тусламжийн зорилго	2
2. Багц тусламжийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл	3
2.1 Хамрагдах сургууль	3
2.2 Багц тусламжийн нэгдсэн төсөв	4
2.3 Сургууль тус бүрт ногдох багц тусламжийг тооцоолох аргачлал	5
2.4 Санхүүжүүлэх үйл ажиллагаа	7
2.5 Багц тусламжийг хэрэгжүүлэхэд тавигдах шаардлагууд.....	10
2.6 Төлөвлөлт ба хяналт	11
2.7 Багц тусламжийг сургуулиудад хуваарилах үйл явц	11
2.8 Бараа, үйлчилгээ худалдан авах.....	12
2.9 Тайлагнах үйл явц ба тавигдах шаардлага	13
2.10 Олон нийтэд таниулан сурталчлах стратеги	14
2.11 Оролцогч талуудын хүлээх үүрэг	14
3. Дүгнэлт	19
3.1 Багц тусламжийн төлөвлөлт	19
3.2 Дараагийн алхмууд.....	20

Хавсралтууд

1. Багц тусламжийн танилцуулга

1.1 Сургуулийн санхүүжилт



Засгийн газраас бага болон дунд боловсролд зарцуулах нийт хөрөнгийн хэмжээ сүүлийн таван жилийн хугацаанд үлэмж хэмжээгээр нэмэгдсэн. Тухайлбал 2010 оны төсөв нь (216.3 сая төгрөгийн урсгал зардал) 2005 онтой харьцуулбал бараг гурав дахин их байна. Байдал хэдий ийм боловч Монголын эдийн засагт ихээхэн ач холбогдол бүхий ашигт малтмалын дэлхийн үнэ ханш санхүү, эдийн засгийн хямралаас улбаалан унасантай холбоотойгоор засгийн газрын нийт төсөв хумигдахад хүрч үүний уршгаар боловсролын салбарын бага, дунд боловсролд зарцуулах хөрөнгийн хэмжээ нэмэгдэх бус, тогтонги байдалд ороход хүрээд байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1а: Боловсролын салбарын урсгал зардал, 1-12 анги, 2005-2010, сая төгрөг

Зарлагын зүйл анги	Бодит зарцуулалт					Төсөв
	2005	2006	2007	2008	2009	2010
Цалин хөлс	46,346.6	63,889.9	92,084.6	140,123.9	144,691.9	149,627.0
Тогтмол зардал	15,502.0	18,275.2	20,122.8	23,368.9	25,628.4	26,772.1
Хувьсах зардал	7,163.5	7,374.9	8,727.6	14,142.3	8,815.6	8,959.3
Хоол	4,083.3	7,487.1	6,325.6	23,035.0	8,194.9	8,647.4
Татаас, шилжүүлэг	560.0	0.0	1,488.4	5,668.0	18,684.8	22,311.2
Бүгд	73,655.4	97,027.0	128,749.0	206,338.1	206,015.6	216,317.1

Хүснэгт 1б: хувиар илэрхийлбэл

Цалин хөлс	62.9%	65.8%	71.5%	67.9%	70.2%	69.2%
Тогтмол зардал	21.0%	18.8%	15.6%	11.3%	12.4%	12.4%
Хувьсах зардал	9.7%	7.6%	6.8%	6.9%	4.3%	4.1%
Хоол	5.5%	7.7%	4.9%	11.2%	4.0%	4.0%
Татаас, шилжүүлэг	0.8%	0.0%	1.2%	2.7%	9.1%	10.3%
Бүгд	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%



Эх үүсвэр : БСШУЯ

Боловсролын салбарын төсвийн зардлын зүйл анги цаг үеийн шаардлагын аясаар өөрчлөгдсөөр ирсэн. Цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл хэмээх төсвийн ангилалд нийт төсвийн дийлэнх нь зарцуулагддаг болохыг дээрх хүснэгтээс харах боломжтой (70% орчим). Харин цалин хөлснөөс бусад урсгал зардалд багтах тогтмол зардал (гэрэл цахилгаан, түлш,

халаалт, тээвэр шатахуун, цэвэр бохир ус), үдийн цай хөтөлбөр болон бусад татаас ба урсгал шилжүүлэг зэргийн хэмжээ 2005 онд 9.7% байснаа 2010 онд 4.1% болж буурчээ.

‘Хувьсах бусад зардалд’ захиргаа, аж ахуйн зардал, бичиг хэрэг, хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардал, эд хогшил худалдан авах, урсгал засвар хийх зардлууд багтана. Байгууллагын үндсэн хөрөнгийг хэвийн хэмжээнд хадгалж, боловсролын орчныг сайжруулахад эдгээр зардлын зүйл анги ихээхэн ач холбогдолтой юм. Сүүлийн таван жилийн хугацаанд цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, гэрэл цахилгаан, цэвэр, бохир ус болон үдийн цай хөтөлбөр зэргийн зардлын зүйл ангийг эс тооцвол бусад зүйл ангийн төсөв нь ямар нэгэн байдлаар нэмэгдэх аль эсвэл нэг хэмжээнд тогтож хадгалагдах хандлагатай байсан байна. Гэсэн хэдий ч яг энэ хугацаанд ‘хувьсах бусад зардлын’ зүйл ангид багтдаг санхүүжилтийн хувь хэмжээ бодит үнийн дүнгийн хувьд багассан нь ажиглагдаж байна.

Нэг талаас БСШУЯ-ны норматив тогтоох аргачлал, нөгөөтэйгүүр, ‘хувьсах бусад зардлын’ зүйл ангид ногдох төсөв сүүлийн хоёр жилийн хугацаанд танагдсантай тус тус холбоотойгоор урсгал засвар хийх, эд хогшил худалдан авах зардал нилээд буурсан. Сургалтын орчинг сайжруулахад эцэг эхийн болон бусад сайн дурын хандив, тусламжинд тулгуурлахаас өөр аргагүй болсон сургуулиуд нилээдгүй байна.

Иймд Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтаар хэрэгжиж буй “Санхүүгийн хямралын үед эмзэг бүлгийн иргэдэд боловсролын үйлчилгээ хүргэх” төслийн хүрээнд боловсролын салбарт учирч буй санхүүгийн хямралыг даван туулахад Ерөнхий боловсролын сургуулиудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор багц тусламжийг олгохоор болсон¹.

1.2 Багц тусламжийн зорилго

Дээрх нөхцөл байдалд үндэслэн багц тусламжийн дараахь байдлаар тодорхойлсон. Үүнд:

- Нэгдүгээрт, олон улсын санхүү, эдийн засгийн хямралаас улбаалан боловсролын чанарт нилээдгүй үүрэг гүйцэтгэх салбарын төсвийн зарим зүйл анги, тухайлбал хичээл, дадлага ажлын зардлын зүйл ангид багтах шохой, лабораторийн материал, жижиг эд хогшил, нөгөөтэйгүүр, сургуулийн барилга байгууламжийг засаж янзлах засвар үйлчилгээний зардалд хуваарилагддаг төсөв сүүлийн хоёр жилийн хугацаанд эрс багассан.
- Хоёрдугаарт, төсвийн нормативт хуваарилалтыг сургуулиуд өөрийн хэрэгцээнд нийцүүлэн төлөвлөх, захиран зарцуулах, шийдвэр гаргах хэмжээний эрх мэдэл сургуулиудад байхгүй учраас сургуульд тулгамдаж

¹ Төсөл хэрэгжүүлэх үндэслэлтэй дэлгэрэнгүй байдлаар танилцахыг хүсвэл “Багц тусламжийн хүрээг тодорхойлох” хэмээх зөвлөхүүдийн тайланттай танилцана уу.

буй бодит асуудлыг шийдвэрлэх боломж гардаггүй гэж хэлж болно. Сургуулиуд жинхэнэ утгаар нь төлөвлөлт хийх боломжгүйгээс сургуулийн удирдах зөвлөлийн ач холбогдол ч буурсан байна.

- Гуравдугаарт, бага, дунд боловсролыг хэдийгээр үнэ төлбөргүй олгодог ч эцэг эхээс анги танхимын тохижилт, засварын мөнгийг ‘сайн дурын’ үндсэн дээр татаж авах нь нэгэнт тогтсон, хэвшмэл зүйл болоод байгаа. Гэсэн хэдий ч оршин сууж буй газрын эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан сургуулиудад сайн дурын хандив өргөх эцэг эхийн боломж харилцан адилгүй байгаа юм.

Дээрх нөхцөл байдлыг сайжруулах үүднээс 2010/2011, 2011/2012 оны хичээлийн жилүүдэд зарим сургуулиудыг сонгон авч, багц тусламжийг туршин хэрэгжүүлэх бөгөөд тусламжийн зорилго нь:

- Багц тусламжийг ‘хувьсах бусад зардал’ гэсэн төсвийн хамгийн их танагдсан зүйл ангид оновчтой хуваарилалт хийх;
- Орон нутгийн төлөвлөлт, менежментийн чиг үүргийг сайжруулах зорилгоор сургуулиудад багц тусламжаар олгогдож буй санхүүжилтийг захиран зарцуулах тодорхой эрх мэдэл олгох;
- Сургуулийн үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог идэвхжүүлж, орон нутгийн хяналтыг нэмэгдүүлэх;
- Ядуурлын мэдрэмж бүхий төсөв хуваарилалтын аргыг нэвтрүүлэх замаар сургуулийн урт хугацааны төсөв хуваарилалтыг сайжруулах гэсэн зорилтуудын хүрээнд хэрэгжинэ.

2. Багц тусламжийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл

2.1 Хамрагдах сургууль

Бараа, үйлчилгээний зардлын зүйл ангийн төсвийн хуваарилалт, ялангуяа, засвар үйлчилгээ, жижиг эд хогшил худалдан авах зэрэг төсвийн хуваарилалт нийт сургуулийн хувьд багассантай холбоотойгоор Монгол улсын төрийн өмчийн бүх сургууль багц тусламжинд хамрагдах үндэслэлтэй гэж үзэж болно. Гэсэн хэдий ч төслийн санхүүгийн боломж хязгаарлагдмал учир сургуулиудад нэмэр болохуйц хэмжээний нэмэлт төсөв хүргэх үүднээс тодорхой сонголт хийхээс өөр аргагүй болсон. Төслийн болон багц тусламжийн зорилгод нийцүүлэх үүднээс сургуулиудын ядууралд өртсөн байдлыг багц тусламжинд хамрагдах нэгэн шалгуур болгон авч үзсэн. Үүнийг хоёр арга замаар тодорхойлсон болно. Үүнд:

Нэгдүгээрт, багц тусламжийн туршилтын төслийг харьцангуй ядуу аймгуудад хэрэгжүүлж эхлэх бөгөөд тэдгээр аймгуудын төрийн өмчит бүх² сургууль төсөлд хамрагдана. Хоёрдугаарт, төслийн хүрээнд сайн дурын (эцэг эх буюу бусад эх үүсвэрээс) нэмэлт хандив цуглуулах боломжгүй сургуулиудад нь

2

Багц тусламжинд хувийн өмчит сургуулиуд хамрагдах боломжгүй. Учир нь хувийн сургуулиуд сурагчдын эцэг эхээс сургалтын төлбөр авдаг ба тэдгээр нь сургуулийн үйл ажиллагааны зардалд зарцуулагддаг юм. Тийм ч учраас төрийн өмчит сургуулиудад тулгамддаг асуудлууд хувийн өмчит сургуулиудад гардаггүй гэж хэлж болно.

арай илүү төсөв ногдох боломжтой байдлаар багц тусламжийг хуваарилах аргачлалыг боловсруулсан юм. Энэхүү аргачлалыг цааш дэлгэрүүлэн тайлбарлах болно. Багц тусламжийн хэрэгцээнд ядуу хэмээх аймгуудыг “Хүн амын тооллогод үндэслэсэн ядуурлын зураглал”-ын тусламжтайгаар тодорхойлсон (ЗГ/НҮБХХ, 2009).

Ядуурлын төвшний судалгааны дүнд үндэслэн Ховд, Дорнод, Хөвсгөл хэмээх нэн ядуу гурван аймагт багц тусламжийн туршилтын төслийг эхлүүлнэ. Эдгээр гурван аймаг гурван өөр бүс нутагт хамаарагдах бөгөөд нийлээд төрийн өмчийн сургуулийн болон төрийн өмчит сургуульд суралцагсдын 12-оос 13%-ийг бүрдүүлдэг.

Хүснэгт 2 : Багц тусламжинд хамрагдах аймгууд (2010/11 хичээлийн жил)

Аймаг	Бүс нутаг	Сургууль ийн тоо	Сурагчдын тоо	Нэг сургуульд ногдох хүүхдийн тоо	Сургуулийн тоо нийлбэр		Сурагчдын тоо нийлбэр	
					Бүгд	%	Бүгд	%
2010/11 оны туршилтын төсөл:								
1. Ховд	Баруун	23	20,409	887	23	3.8%	20,409	4.1%
2. Дорнод	Зүүн	23	13,966	607	46	7.6%	34,375	7.0%
3. Хөвсгөл	Хангай	34	25,948	763	80	13.2%	60,323	12.2%
Монгол улс		605	493,111	815	605	100.0%	493,111	100.0%

Туршилтын төслийн хоёрдахь буюу 2011/12 оны хичээлийн жилд төрийн өмчит 150 – 200 сургууль багц тусламжинд хамрагдах бөгөөд ингэснээр улсын хэмжээнд нийт төрийн өмчит сургуулийн 40 хувь буюу түүнээс дээш хэмжээний сургууль уг төсөлд хамрагдах боломжтой болно.

Багц тусламжийг цаашид энэ хэвээр нь өргөжүүлэн хэрэгжүүлэх буюу багц тусламжийн туршилтын төслийн үр дүнд үндэслэн сургуулиудыг санхүүжүүлэх системд өөрчлөлт оруулснаар багц тусламжийг бусад сургуулиуд ч хүртэх боломжтой болно. Хоёрдахь жилийн туршилтын төсөлд хамрагдах сургуулиудыг ядуурлын үзүүлэлт дээр үндэслэн сонгохын сацуу бүс нутгийн тэгш байдал, төслийн эхний жилийн багц тусламжийн туршилтын төслийн хэрэгжилтийн явцын үнэлгээнд тулгуурлан сонгон шалгаруулах болно.

2.2 Багц тусламжийн нэгдсэн төсөв

Өнөөгийн байдлаар ‘үйл ажиллагааны бусад зардлын’ зүйл ангид сургууль тус бүрт төсвөөс 11.75 сая төгрөг (8,800 Ам.доллар) орчим ногддог бөгөөд энэ нь тухайн сургуулийн төсвийн 4%-ийг бүрдүүлдэг. Багц тусламжийг хүртснээр энэхүү дүн нь хоёр дахин нэмэгдэж, улмаар бусад үйл ажиллагааны зардлын төсөв эргээд 8 хувь хүртлээ өсөх боломжтой болно.

Багц тусламжийн төслийг хэрэгжүүлэх нийт төсөв нь 3.1 сая доллар бөгөөд туршилтын төслийн эхний жилд нь 80, дараагийн жилд 190 сургуулийг нэмж хамруулах боломжтой байдлаар боловсруулагдсан.

Хүснэгт 3: Багц тусламжийн санхүүжилт, хичээлийн жилээр, ам доллар, төгрөгөөр

Хичээлийн жил	Сургуулийн тоо	Нэг сургуульд ногдох хэмжээ		Нийт төсөв	
		Ам доллар	Төгрөг*)	Ам доллар	Сая төгрөг
2010/11	80	8,850	11,770,000	708,000	941.6
2011/12	270	8,850	11,770,000	2,389,500	3,178.0
Хоёрдугаар жилд нэмэгдэх сургуулийн тоо: 190		-	-	3,097,500	4,119.6

*) Нэг ам.долларын ханш 1330 төгрөг байхаар тооцоолов

2.3 Сургууль тус бүрт ногдох багц тусламжийг тооцоолох аргачлал

Багц тусламжийг хэрэгжүүлэх бодлогын шинж чанартай зорилтуудад нийцүүлэн сургууль тус бүрт хуваарилагдах багц тусламжийн хэмжээг тодорхойлох аргачлалыг боловсруулах шаардлагатай болсон. Ингэснээр сургууль тус бүр өөрийн 'хувьсах бусад зардлын' хэрэгцээнд нийцсэн тусламжийг хүртэх боломжтой болох ба томьёололд сурагчдын тоо, дотуур байрны хүүхдийн тоо, сургуулийн үндсэн хөрөнгийн хувь хэмжээ гэх мэт 'хувьсах бусад зардалд' хамаарах үзүүлэлтүүдийг багтаахаас гадна сургуулийн гаднын бусад эх үүсвэрээс хөрөнгө босгох чадавхийг ч нэгэн үзүүлэлт болгон оруулсан (үүнд эцэг эхээс босгох сайн дурын хандивыг ч багтаасан) болно.

Сургууль тус бүрт ногдох хувь хэмжээг тодорхойлох энэхүү аргачлал нь статистикийн тоо баримтанд тулгуурласан, бодит байдалд нийцсэн, хэн бүхэнд ойлгомжтой байдлаар илэрхийлэгдсэн учраас хэрэглэхэд дөхөмтэй. Хэрэгцээ ихтэй сургуульд ихийг хүртэх боломж олгодгоороо энэхүү аргачлалын давуу тал оршино.

Сургуулиудад хуваарилах багц тусламжийн хувь хэмжээг тодорхойлох аргачлал нь ядуурлын төвшинг харгалзахын сацуу сургуулийн 'хувьсах бусад зардлын' төсвийг нэмэгдүүлэх учиртай. Багц тусламжийн санхүүжилтийг хуваарилахдаа дараах хүчин зүйлүүдийг харгалзан тооцоолсон. Өөрөөр хэлбэл, нийт олгогдох тусламжийг 100% гэж үзвэл түүний:

<u>Хувьсагч</u>	<u>Эзлэх жин</u>
Сургууль бүрийн зайлшгүй хүртэх хувь	10%
Сурагчдын тоо	25%
Анги танхимын тоо	20%
Дотуур байрны сурагчдын тоо	20%
Аймгийн төвөөс алслагдсан байдал	5%
Сумын ядуурлын төвшин	20%

Томьёолол нь дараахь ач холбогдолтой:

- Сургууль бүр заавал авах буюу зайлшгүй хүртэх хувьтай байна (Энэ нь нийт төсвийн 10%-ийг хамрагдах сургуулийн тоонд хуваасан хувь хэмжээ юм). Ингэснээр жижиг буюу ядуу хэмээх ангилалд багтаж байдаг сургуулиуд багц тусламжаар дэмжигдэнэ;
- 'Хувьсах бусад зардлыг' тооцоолоход сурагчдын тоог заавал анхаардаг учраас олон сурагчтай сургууль багц тусламжийг арай ихээр хүртэнэ;
- Анги танхимын тоо олонтой сургууль багц тусламжийг ахиу хүртэнэ. Анги танхимын тоо нь үндсэн хөрөнгийн хэмжээний хувьсагч болж өгөхийн зэрэгцээ шаардагдах засвар үйлчилгээний хувьсагчийн үүргийг ч давхар гүйцэтгэнэ;
- Дотуур байрны хүүхдийн тоо олон байх тусмаа багц тусламжийг ахиу хүртэх нөхцөл бүрдэнэ. Учир нь дотуур байртай сургууль нь дотуур байргүй сургуулиас илүү зарлагатай (жишээ нь: дотуур байрны нэг хүүхдэд ногдох нормативт засвар үйлчилгээний зардал багтдаггүй юм) байхаас гадна дотуур байртай сургуулиуд ядуу айл өрхийн хүүхдүүдэд үйлчлэх боломжтой гэсэн үндэслэлээр энэхүү хувьсагчийг сонгосон юм;
- Аймгийн төвөөс алслагдсан байршилтай сургуулиуд багц тусламжийг арай ихээр хүртэх боломжтой. Учир нь аймгаас хол орших тусмаа өртөг нэмэгддэг гэсэн үндэслэл бий; Эцэст нь
- Ядууралд илүү өртсөн суманд байрлах сургуульд багц тусламжийг ахиу хуваарилна. Үүнийг ядуу сумын эцэг эхийн санхүүгийн чадавхитай холбон үзэж байгаа юм.

Хавсралт 1-д 2010/11 оны хичээлийн жилд багц тусламжинд хамрагдах сургууль болон тэдгээр сургуульд ногдох багц тусламжийн хувь хэмжээг тодорхойлсныг харуулсан. Сургууль бүрийн хувьсагчийн хувь хэмжээнээс шалтгаалан сургууль тус бүрт ногдох багц тусламжийн хувь хэмжээ харилцан адилгүй байх хэдий ч багийн сургууль тус бүр дунджаар 3.4 сая төгрөг, сумын сургууль тус бүр 11.7 сая төгрөг, аймгийн төвийн сургууль тус бүр 13.5 сая төгрөг хүртэх боломжтой.

Энэ хуваарилалт нь сургуулиудад төсвөөс олгогддог 'хувьсах бусад зардлыг' ямар нэг хэмжээнд хоёр дахин нэмэгдүүлэх боломжтой болгох юм. Сургууль тус бүрт ногдох багц тусламж харилцан адилгүй байх ба нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж нормативыг тооцоолохоос өөр аргачлалыг хэрэглэсэн учраас сургуулиудын хүртэх хувь хэмжээ өөр өөр байгаа юм (Хүснэгт 4).

Хүснэгт 4 : Сургууль тус бүрт ногдох багц тусламжийн хувь хэмжээ, 2010/11, Төгрөгөөр

			Бүх сургууль N=80	Багийн сургууль N=4	Сумын сургууль N=54	Аймгийн сургууль N=22
Хувьсагч : Зайлшгүй хүртэх Сурагчдын тоо Дотуур байрны хүүхдийн тоо Анги танхимын тоо Аймгийн төвөөс алслагдсан байдал Сумын ядуурлын төвшин	Эзлэх жин	Бүгд :				
	10%	Доод	2,462,300	2,462,300	4,040,902	2,870,152
	25%	Дээд	22,178,350	4,813,835	20,881,861	22,178,350
	20%	Дундаж	11,770,500	3,366,555	11,685,541	13,507,026
	20%	Голч дүн	11,585,306	3,095,042	11,445,774	13,665,594
	5%					
	20%	Сурагч тус бүрт :				
		Доод	8,993	52,899	13,377	8,993
		Дээд	82,254	82,254	32,302	18,584
		Дундаж	19,868	62,433	19,788	12,327
		Голч дүн	17,846	57,290	19,257	12,006
		Анги танхим тус бүрт :				
		Доод	340,345	492,460	421,630	340,345
		Дээд	1,858,550	1,203,459	1,858,550	798,907
		Дундаж	692,139	733,484	768,682	496,745
		Голч дүн	647,031	619,008	709,276	491,211

2.4 Санхүүжүүлэх үйл ажиллагаа

Багц тусламжийн зорилтуудад нийцүүлэн сургуулиудад тодорхой хэмжээний эрх мэдлийг олгох бөгөөд ингэснээр сургуулиуд нэмэлт төсвөө хэрхэн яаж зарцуулахыг өөрсдөө төлөвлөх боломжтой болно. Гэсэн хэдий ч багц тусламжийн хүрээнд гарах нийт зарлага нь заавал 'хувьсах бусад зардал' хэмээх зүйл ангид хамаарахаар зохион байгуулагдсан байх бөгөөд энэхүү зүйл ангид хамаарахгүй үйл ажиллагаанд зарцуулагдах боломжгүй байна. Багц тусламжийг 'бусад хувьсах зардал' хэмээх зүйл ангид багтдаг бүхий л үйл ажиллагаанд зарцуулах боломжтой байх бөгөөд үүнд 'шагнал урамшуулал' хэмээх зүйл анги л хамаарахгүй болно. Тиймээс Хүснэгт 5-д заасан 'хувьсах бусад зардлын' үндсэн долоон зүйл ангийн алинд нь ч зарцуулалт хийж болно.

Хүснэгт 5 : Санхүүжүүлэх үйл ажиллагаа

1. Захиргаа удирдлагын зардал

- Бичиг хэрэг
- Шуудан, харилцаа холбоо
- Дотоод томилолт

2. Багшийн хөгжил, сургалтын зардал

- Ном, хэвлэл авах

3. Цэвэрлэгээ, үйлчилгээний зардал

- Нормын хувцас
- Эм

4. Хичээлийн хэрэглэгдэхүүн

Шохой, газрын зураг, газар зүйн хичээлийн хэрэглэгдэхүүн, гарын авлага гэх мэт

5. Биеийн тамир, спортын уралдаан тэмцээн

- Уралдаан, тэмцээнд оролцох зардал

6. Тавилга, тоног төхөөрөмж худалдаж авах (хичээлийн анги танхим, цайны газар, дотуур байрны хэрэгцээнд)

- Жижиг эд хогшил худалдан авах

7. Урсгал засвар (хичээлийн анги танхим, цайны газар, дотуур байрны хэрэгцээнд)

- Байрны урсгал засвар

Санхүүжүүлэх үйл ажиллагааны зардлын дэлгэрэнгүй тайлбар болох (тод хараас бусад фонтоор бичигдсэн) дэд зүйл ангиуд нь сургуулийн төсвийн нэгэнт хэвшчихсэн зүйл ангиуд бөгөөд (Ердийн сургуулийн төсвийн задаргаа - Хавсралт 22) багц тусламж нь эдгээр зүйл ангийн хүрээнд хэрэгжих учраас багц тусламж одоо мөрдөгдөж буй тогтолцооны хүрээнд хэрэгжинэ гэж хэлж болно.

Нэгдүгээрт, багц тусламжийг боловсролын салбарын үзүүлэлтэд чухал нөлөө үзүүлэх, хоёрдугаарт, хүрэлцэхгүй байсан төсөвт нэмэр болохуйц хэмжээнд багц тусламжийг хэрэгжүүлэхийн тулд дараах зүйлийг мөрдлөгө болгон ажиллана. Үүнд:

- Багц тусламжийн зарцуулалт нь боловсролын салбарын бодлогын тэргүүлэх чиглэл буюу Боловсролын салбарын мастер төлөвлөгөө ба Монгол Улсын засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны боловсролын салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдаж байх ёстой;
- Багц тусламжийн 25 хүртэлх хувийг сургалтын материал, хичээлийн хэрэглэгдэхүүн худалдан авахад зарцуулна (4 дүгээр зүйл анги);
- Багц тусламжийн 60 хүртэлх хувийг тавилга эд хогшил худалдаж авах, засвар, тохижилтийн ажил хийхэд зарцуулна (6 ба 7 дугаар зүйл анги);

Өөрөөр хэлбэл багц тусламжийн 15 хүртэлх хувийг л 1,2,3 ба 5 дугаар зүйлд зарцуулах боломжтой байна.

Багц тусламжийг хүртэх шаардлагыг хангахын тулд дээрх зүйлүүдийг мөрдлөг болгон ажилласнаа сургуулиуд заавал нотлох ёстой бөгөөд үүнийгээ багц тусламжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөндөө тусгасан байна.

Баг тусламжийг хэрэгжүүлэх боломжит хувилбар болон шаардлагуудыг Хүснэгт 6-д дахин үзүүлсэн болно.

Хүснэгт 6 : Санхүүжүүлэх үйл ажиллагаа

Зардлын задаргаа	Төсвийн холбогдох зүйл анги		Боломжит үйл ажиллагаа (өөр хувилбар ч байж болно)	Эзлэх хэмжээ	хувь	
	Код	Тайлбар				
1. Захиргаа, удирдлагын зардал	0000	Бичиг хэрэг	Захиргаа, удирдлагын зардалд хамаарах, төсвийн уг зүйл ангитай нийцэх үйл ажиллагаа.	Нийт төсвийн 15-аас илүүгүй хувь		
	0000	Шуудан, харилцаа холбоо				
	0000	Дотоод томилолт				
2. Багшийн хөгжил, сургалтын зардал	0000	Ном, хэвлэл авах	Ном, сэтгүүл, сургалтын гарын авлага			
3. Цэвэрлэгээ, үйлчилгээний зардал	0000	Нормын хувцас	Цэвэрлэгээ, үйлчилгээний ажилтнуудын эрхэлсэн ажилтай холбоотой үйл ажиллагааг багтаана (захиргааны туслах ажилтан, тогооч, харуул гэх мэт)			
	0000	Эм				
4. Биеийн тамир, спортын уралдаан тэмцээн	0000	Спортын уралдаан тэмцээн	Уралдаан, тэмцээнд оролцох сурагчдын зардлыг багтаана			
5. Хичээлийн хэрэглэгдэхүүн	0000	Хичээлийн хэрэглэгдэхүүн	Самбарын шохой, хими, газар зүй, биеийн тамир, биологийн хичээлд хэрэглэгдэх сургалтын хэрэглэгдэхүүн, сургалтын материал үйлдвэрлэх тоног төхөөрөмж: хувилагч машин, LCD, компьютер	Нийт төсвийн 25-аас илүүгүй хувь		
6. Тавилга, тоног төхөөрөмж худалдаж авах	0000	Жижиг эд хогшил худалдан авах	Анги танхим, гал тогоо, дотуур байрны зориулалт бүхий жижиг эд хогшил (цагаан хэрэглэл, тоглоом), тавилга, овор багатай (анги танхим, гал тогоо, дотуур байрны үндсэн) цахилгаан бараа худалдаж авах	Нийт төсвийн 60-аас илүүгүй хувь		
7. Урсгал засвар, тохижилт	0000	Байшин барилгын урсгал засвар	Анги танхимын шал, сургууль, дотуур байрны дээвэр, халуун усны шугам хоолой засах, Дотуур байрны орчин, ариун цэвэр, усны хангамжийг сайжруулах			

2.5 Багц тусламжийг хэрэгжүүлэхэд тавигдах шаардлагууд

Сонгогдсон аймгийн төрийн өмчит бүх сургууль багц тусламжинд хамрагдах эрхтэй байхын зэрэгцээ төсөлд хамрагдснаар багц тусламжийг хэрэгжүүлэх эрхэм үүрэг давхар ногдож байгааг ухамсарлах нь зүйтэй:

Төлөвлөлт ба хяналт

- Сургууль бүр сургуулийн удирдах зөвлөлөөс гарсан санал зөвлөмжид үндэслэн өгөгдсөн маягтын дагуу багц тусламжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулна.
- Төлөвлөгөөг сургуулийн удирдах зөвлөлийн бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлж, захирал буюу бусад удирдлагыг төлөөлж нэг хүн, эцэг эхийн төлөөлөл нэг хүн, нийт гурваас доошгүй зөвлөлийн гишүүний гарын үсгээр баталгаажуулсан байна. Ингэхдээ, зөвлөлийн гишүүд жинхнээсээ хуралдсан, тэдгээрийн санаа оноог тусгасныг ямар нэгэн байдлаар баталгаажуулж, баримтжуулсан байх шаардлагатай.
- Сургуулийн удирдах зөвлөл нь улирал тутам багц тусламжийн хэрэгжилтийг хэлэлцэж байх ёстой бөгөөд хурлын протоколыг хөтөлнө.

Хамтын санхүүжилт

- Сургууль бүр хийсэн төлөвлөгөөнийхөө тодорхой хэсгийг өөрийн санхүүгийн эх үүсвэрээс (сургуулийн өөрийн орлого, хандив) гаргах ёстой. Багийн сургуулийн хувьд төлөвлөгөөний нийт төсвийн 2,5%, сумын сургуулийн хувьд 7,5%, аймгийн төвийн сургуулийн хувьд 12,5% нь өөрийн эх үүсвэрээс гарна. Эдгээр хамтын санхүүжилт нь сургуулийн төрийн сангийн дансаар дамжсан байх зохистой.

Бараа, үйлчилгээ худалдан авах

- Сургуулиуд Монгол улсын “Бараа, ажил үйлчилгээ, худалдан авах” хууль, холбогдох журмыг дагаж мөрдөнө. Сургуулийн удирдах зөвлөл багц тусламжийн хүрээнд бараа материал худалдан авах тендерийн хороо байгуулж түүгээр дамжуулан бараа үйлчилгээ худалдан авна.
- Багц тусламжийн хүрээнд бараа материал худалдан авахдаа 3-с доошгүй байгууллагын үнийн саналыг харьцуулан үнэлэх аргаар хийнэ. Худалдан авахын өмнө тендерийн хороо эдгээр саналыг үнэлэн, дүгнэлт гаргана.

Тайлагнах (санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан)

- Худалдан авалт ба санхүүгийн болоод багц тусламжийн хэрэгжилтийн явцын тайлан нь Монгол улсын хууль, журмын хүрээнд хийгдэнэ. Багц тусламжийн хэрэгжилтийн талаарх явцын тайланг Аймгийн БСГ (нэг хувийг нь аймгийн Төрийн санд)-т улиралд нэг удаа бичиж өгөх шаардлага нэмэлтээр орж байгаа юм.
- БСШУЯ (эсвэл Аймгийн БСГ)-нд өгсөн тухайн сургуулийн багц тусламжийн үйл явцын тайланг хангалтгүй гэж үзсэн тохиолдолд тусламжийг зогсоож болно.
- Үйл явцын тайланг жилийн турш хангалтгүй байдлаар өгөх буюу жилийн эцсийн тайланг хангалтгүй хэмжээнд ирүүлбэл 2 дахь жилийн багц тусламжийн хуваарилалтаас уг сургуулийг хасах болно.

Сургуулиудыг багц тусламжинд албадан хамруулахгүй. Харин багц тусламжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг ирүүлж (гэрээнд гарын үсэг зурагдснаар), улмаар төсөлд хамрагдснаар багц тусламжийг хэрэгжүүлэх үүргийг сургуулиудад хүлээлгэх болно.

2.6 Төлөвлөлт ба хяналт

Сургуулиуд Хавсралт 3-т үзүүлсний дагуу багц тусламжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулсан байна. Багц тусламж болон багц тусламжийг хэрэгжүүлэх төсөв төлөвлөгөөг засгийн газрын санхүүгийн жилтэй уялдуулах (1 сарын 1-ээс 12 сарын 31) нь зохимжтой байсан боловч төслийн үйл ажиллагаанд нийцүүлэн багц тусламжийг хоёр хичээлийн жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр болсон (8 сарын 1-ээс 6 сарын 30).

Багц тусламжийн төслийн эхний үе шатыг 2010 оны 10 сарын 1-нээс 2011 оны 6 сарын 30 хүртэл, хоёрдугаар үе шатыг 2011 оны 8 сарын 1-нээс 2012 оны 6 сарын 30-ныг хүртэл хэрэгжүүлнэ.

Төслийн хүрээнд сургуулийн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилт тавьсантай холбогдуулан сургуулийн удирдах зөвлөлийг багц тусламжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, нэн ялангуяа багц тусламжийн хүрээнд хэрэгжих үйл ажиллагааг хэлэлцэх үйл явцад оролцуулах нь онцгой ач холбогдолтой.

Сургуулийн захиргаанаас Аймгийн БСГ-т хүргүүлэхээр бэлтгэсэн улирлын тайланд үндэслэн улиралд нэг удаа багц тусламжийн хэрэгжилтийн явцыг удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэх нь мөн чухал ач холбогдолтой (доорхи хавсралтаас үзнэ үү).

2.7 Багц тусламжийг сургуулиудад хуваарилах үйл явц

Багц тусламжийг хуваарилах зарчмын хувьд мөнгө санхүү хуваарилах засгийн газрын ердийг тогтолцоог ашиглана. Төрийн сан нь шаардагдах өөрчлөлтийг хийснээр багц тусламжийн хэрэгжилттэй холбоотой орлого, зарлагыг сургуулийн төсвөөс харах боломжтой болно.

Багц тусламжийг нэгэнт сургуулиудад шилжүүлэх тохиролцоонд хүрснээр (сургуулиудаас ирүүлсэн төсөв, төлөвлөгөөнд үндэслэн) дараахь байдлаар ажиллана. Үүнд:

- БСШУЯ батлагдсан төсөв, зарцуулах хуваарийн дагуу Сангийн Яаманд хүсэлт гаргах бөгөөд санхүүжилтийг төслийн данснаас аймаг, сумын төрийн санд байрших сургуулийн дансанд шилжүүлнэ;
- Сургуулиуд багц тусламжаар ирсэн санхүүжилтийг ердийн тогтолцоогоороо дамжуулан (төрийн сан) хүлээн авах ба батлагдсан хуваарийн дагуу зарцуулна. Сургуулиуд санхүүжилтийн нийт дүнг хэтрүүлэн зарцуулж болохгүй хэдий ч шаардлагатай гэж үзвэл төсөвлөгдсөн зүйл анги нэг бүрийн зарцуулалтыг таваас илүүгүй хувиар дутуу буюу хэтрүүлэн зарцуулж болно. Харин таваас дээш хувиар дутуу

буюу хэтрүүлэн зарцуулах тохиолдолд БСШУЯ-аас урьдчилж зөвшөөрөл авсан байх шаардлагатай.

Багц тусламжийг хэрэгжүүлэх явцад засгийн газраас мөрддөг дүрэм журмыг баримтлахын сацуу хэд хэдэн нэмэлт зохицуулалт шаардлагатай байгааг доор дурьдсан. Үүнд:

- Санхүүжилтийн талаарх мэдээллийг олон нийтэд өргөнөөр сурталчилна. Ингэснээр сургуулийн захиргаа, сургуулийн удирдах зөвлөл нь орж ирсэн санхүүжилтийн талаарх бодит мэдээллийг хүлээн авах боломжтой болно;
- Санхүүжилтийг улирал тутам хийх бөгөөд тухайн сар, улиралд зарцуулагдаагүй санхүүжилтийг сургууль захиран зарцуулах эрхтэй хэвээр байна. Харин 2011 оны 6 сарын 30 ба 2012 оны 6 сарын 30-ны байдлаар зарцуулагдаагүй үлдсэн санхүүжилтийг эргүүлэн татах болно;
- Хамтын санхүүжилт буюу сургуулийн оруулж буй хувийг сургуулийн төрийн сан дахь дансанд бүртгүүлж болно;
- Сургуулийн удирдах зөвлөлийн гишүүдээс бүрдсэн тендерийн хороо нь бараа, ажил үйлчилгээг үнийн санал авч, харьцуулах аргаар шийдвэр, дүгнэлтийг гаргана.

2.8 Бараа, үйлчилгээ худалдан авах

Бараа, ажил үйлчилгээ худалдан авах бүх үйл ажиллагааг Монгол Улсын Бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай 2006 оны хуулиар зохицуулна. Хуулийг төрийн өмчит бүх байгууллага, сургууль дагаж мөрдөх бөгөөд энэ нь бараа, үйлчилгээ худалдан авах, ажил гүйцэтгэх захиалга өгөх, бараа үйлчилгээг хамгаалах талаарх төрийн зохицуулалтыг илэрхийлсэн хууль юм. Хуулийн хүрээнд сургууль ч бараа, үйлчилгээ худалдан авах эрх бүхий байгууллага мөн.

Бараа, ажил үйлчилгээг гурван арга замаар худалдан авна: шууд худалдан авах (жижиг бараа, үйлчилгээ), харьцуулах арга замаар худалдан авах (3-ан үнийн саналд үндэслэн) ба зарласан тендерийг тендерийн хороогоор дамжуулан үнэлэх арга замаар худалдан авах гэх зэрэг. Эдгээрээс бусад нөхцөлд бараа, ажил үйлчилгээ худалдан авах эрх бүхий удирдлагууд зохих шийдвэрийг гаргах эрхээр хангагдана.

Бараа, үйлчилгээг аль ангилалд багтаан худалдан авахыг дээр дурьдсан журмын хүрээнд зохицуулдаг бөгөөд одоогийн байдлаар дараахь байдлаар тодорхойлогдсон байдаг юм. Үүнд:

- Бараа, үйлчилгээг шууд худалдан авах
(1 сая төгрөгөөс доош)
- Харьцуулалт хийх арга замаар бараа үйлчилгээ худалдан авах
(Бараа, үйлчилгээ худалдан авахад - 1 сая төгрөгөөс дээш 30 сая төгрөгөөс доош)
(Ажил гүйцэтгүүлэхэд - 1 сая төгрөгөөс дээш 50 сая төгрөгөөс доош)
- Тендер зарлах
(Бараа, үйлчилгээ худалдан авахад 30 сая төгрөгөөс дээш)
(Ажил гүйцэтгүүлэхэд 50 сая төгрөгөөс дээш)

Сургууль тус бүрт ногдох багц тусламжийн хувь хэмжээг харгалзан үзвээс (дээд тал нь 22 сая төгрөг; Хүснэгт 4) сургуулиуд бараа, үйлчилгээг шууд худалдан авах, харьцуулах арга замаар худалдан авах, аль эсвэл дээрх хоёр арга замыг хослуулан бараа, үйлчилгээ худалдан авах боломжтой байх юм.

Багц тусламжийн ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, сургуулийн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх дэд зорилтын хүрээнд харьцуулах арга замаар бараа, үйлчилгээ худалдан авахын тулд сургуулийн удирдах зөвлөлийн гишүүдээс бүрдсэн тендерийн хорооноос урьдчилж зөвшөөрөл авсан байна.

Тендерийн хорооны гишүүдийг сургуулийн удирдах зөвлөлийн бүх гишүүдийг оролцуулсан хурлаар сонгох бөгөөд тендерийн хороонд эцэг эхийн төлөөллөөс нэг буюу хоёр, сургуулийн ажилчдаас нэг буюу хоёр хүнийг тус тус сонгож, нийт гурван хүний бүрэлдхүүнтэйгэр байгуулна.

Тендерийн хороо нь сургуулийн захиргаа буюу нягтлан бодогчоос өгсөн санал зөвлөмжийг хэлэлцэж, дүгнэлт гаргах бөгөөд харьцуулах арга замаар худалдан авах бүрт тендерийн хорооноос урьчилж зөвшөөрөл авсан байх шаардлагатай.

Сургуулийн захиргаа өөрийн эрх мэдлийн хүрээнд бараа, үйлчилгээг шууд худалдан авах бөгөөд улирлын явцын тайланг сургуулийн удирдах зөвлөлөөр (аль эсвэл БСШУЯ, Аймгийн БСГ) хэлэлцэх үеэр шууд худалдан авахтай холбоотой асуудлыг эргэн сөхөж болно.

2.9 Тайлагнах үйл явц ба тавигдах шаардлага

Сургуулиуд нилээн олон төрлийн тайлан бичиж өгдөг бөгөөд тайлан бичих ажилд давхцах зүйл гарч, үр ашгийг тооцоолоход ч бэрх байдаг. Энэхүү байдлыг засаж залруулах үүднээс нэмэлт тайлан бичих шаардлага багц тусламжийг хэрэгжүүлэх явцад зүй ёсоор тавигдах бөгөөд туршилтын хугацаанд тайлагнах үйл явцыг эргэн хянаж, засаж залруулах ажил хийгдэж, улмаар туршилтын төслөөс хуримтуулсан туршлага дээр үндэслэн тайлагнах үйл явцыг сайжруулах тал дээр цаашид анхаарал хандуулна.

Нэгэнт хэвшсэн тайлагнах үйл явцын хүрээнд дараахь тайланг бүрдүүлнэ. Үүнд:

- Төрийн санд явуулах улирал тутмын санхүүгийн тайлан. Үүнд багц тусламжийн хэрэгжилтийн талаарх нэмэлт мэдээллийг оруулж, Аймгийн БСГ-т давхар илгээнэ;
- Төрийн сан нь Аймгийн БСГ, сургуулиудад улирал тутам дансны хуулгыг (шинээр!) илгээх бөгөөд сургуулиуд өөрийн данс тооцоотой тулгаж үзнэ;
- Сургуулиуд зохих дүрэм журмын хүрээнд багц тусламжийг хэрэгжүүлж байгаа эсэхийг хянах үүднээс Аймгийн БСГ-т улирал тутам явцын тайланг бичиж явуулна. Тайлан бичих маягыг Хавсралт 4-өөс үзнэ үү.
- Аймгийн БСГ сургуулиудаас ирүүлсэн тайланг нэгтгэж, БСШУЯ-д хүргүүлнэ. Дүрэм журмын хүрээнд үйл ажиллагаа явуулаагүй сургуульд арга хэмжээ авах, үйл ажиллагааг нь засаж залруулах үүргийг Аймгийн

БСГ хүлээнэ. Аймгийн БСГ-ын ажилтан Боловсролын салбарын ажилтны хувьд багц тусламжийн санхүүжилтийн зарцуулалтыг хянах үүрэг хүлээх бөгөөд санхүүжилтийг зориулалт бусаар ашиглаж байгаа сургуулиудад шилжүүлэх санхүүжилтийг зогсоох хүсэлтийг БСШУЯ-д тавьж болно.

- Хоёрдугаар улирлын тайлан (6 сарын сүүл) нь жилийн эцсийн тайлангийн үүргийг давхар гүйцэтгэнэ.

2.10 Олон нийтэд таниулан сурталчлах стратеги

Багц тусламжийн санхүүжилтийн талаарх мэдээллийг ил тод, нээлттэй байлгах нь төслийн нэг чухал бүрэлдэхүүн хэсэг юм.

Үүнд төрийн төв байгууллага, төрийн сан, аймаг, сумын засаг захиргаа, сургууль зэрэг бүх оролцогч талуудын оролцоог хангасан байна. Сургуулийн орчинд ч сургуулийн удирдах зөвлөлийг үйл ажиллагаанд татан оролцуулснаар санхүүжилтийн талаарх мэдээллийг ил тод байлгах боломж бүрдүүлэн ажиллах боломжтой.

Багц тусламжийн санхүүжилтийн талаарх мэдээллийг нийтэд өргөнөөр сурталчлах бөгөөд шаардлагатай нөхцөлд үндэсний сонинд нийтлүүлэхээс гадна аймаг, сум, сургуулийн зарлалын самбарт мэдээллийг байршуулснаар сургуулийн захиргаа төдийгүй сургуулийн удирдах зөвлөл, эцэг эх, сурагчид багц тусламжийн санхүүжилтийн талаарх бодит мэдээллийг олж авах болно.

Санхүүжилтийн талаарх мэдээллийг нийтэлж олны хүртээл болгосон байдал нь (БСШУЯ, аймаг/сумын боловсролын хэлтэс, сургууль) багц тусламжийг хэрхэн хэрэгжүүлснийг илтгэх нэгэн шалгуур үзүүлэлт болно. Хоёрдугаарт, багц тусламжийн шаардлагад нийцүүлэн багц тусламжийн санхүүжилт болон түүний зарцуулалтын талаарх мэдээллийг (улирлын тайлан) сургуулийн зарлалын самбарт байршуулах үүргийг сургуулийн захиргаа хүлээнэ. Олон нийтэд сурталчлах ажлыг хэрхэн гүйцэтгэснийгээ улирал тутмын тайланд тусгах үүргийг сургуулиуд хүлээнэ.

2.11 Оролцогч талуудын хүлээх үүрэг

Сургуулийн төсвийн тодорхой зүйл ангид нэмэлт төсөв хуваарилахын зэрэгцээ сургуулийн удирдах зөвлөлийг багц тусламжийн төлөвлөлт, сургуулийн захиргаа удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавихад татан оролцуулах ажил төслийн хүрээнд хийгдэх ёстой. Сургуулийн удирдах зөвлөлийг идэвхжүүлснээр төвлөрлийг сааруулах, орон нутагт эрх мэдлийг хуваарилах ажлыг ч сайжруулах боломжтой болно.

Сургуулийн удирдах зөвлөл төслийн төлөвлөлт, бараа, үйлчилгээ худалдан авах, тайлагнах зэрэг бүх ажилд оролцоно. Эдгээр шинэ үүргийг дээр дурьдсан байгаа.

Хэдийгээр хэвшсэн тогтолцоогоор дамжуулан төслийн үйл ажиллагааг явуулахаар болж байгаа ч Аймгийн БСГ-ууд дараахь үүргийг нэмж хүлээнэ. Үүнд:

(а) Сургуулиудаас ирүүлсэн төсөл төлөвлөгөөг хянах, (б) төсөл төлөвлөгөөгөө боловсруулж чадахгүй байгаа сургуулиудад арга зүйн туслалцаа үзүүлэх, (в) хэрэгжилтийг хянах (г) БСШУЯ-нд тайлагнах ба багц тусламжийг зориулалт бусаар зарцуулж байгаа сургуулийн асуудлыг өөрийн эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэх боломжгүй бол тэдгээр сургуулийн талаарх мэдээллийг БСШУЯ (төслийн баг)-нд өгөх.

Талуудын эрх үүргийг Хүснэгт 7, 8-д тусгасан болно.

Хүснэгт 7: Талуудын хүлээх үүрэг

Оролцогч тал	Хүлээх үүрэг
1. БСШУЯ	- Багц тусламжийн гэрээг сонгогдсон аймгийн БСГ-тай хийх - Багц тусламжийн сургалт зохион байгуулах - Багц тусламжинд хамрагдсан сургуулиудад багц тусламжийн талаарх мэдээлэл өгөх - Хэрэгжилтийг хянах, үнэлэх - Багц тусламжийн санхүүжилтийг Сангийн яам, төрийн сангаар дамжуулан хийх - Хэрэгжилтийг дүгнэх, аймгуудаас ирүүлсэн тайланд холбогдох арга хэмжээ авах
- 2.Төслийн баг	- Сургалт зохион байгуулахад туслалцаа үзүүлэх - Олон нийтэд чиглэсэн кампанит ажил зохион байгуулах - Багц тусламж хэрэгжүүлэх сургуулиудын төсөл, төлөвлөгөөг хянахад БСШУЯ, Аймгийн холбогдох байгууллагад туслалцаа үзүүлэх - Хэрэгжилтийг хянах, үнэлэхэд БСШУЯ, Аймгийн холбогдох байгууллагад туслалцаа үзүүлэх - АХБ-ны гэрээт зөвлөхүүдээр дамжуулан сургуулиудад хяналт хийх
3. Сангийн яам, төрийн сан	- Шаардагдах өөрчлөлтийг оруулах - Аймаг, сумын ажилтнуудад эдгээр өөрчлөлтүүдийн талаар мэдээлэх - Төлбөрийн даалгавар гүйцэтгэх
4. Аймаг, сумын төрийн сан	- Зааврын дагуу сургуулиудад шилжүүлэг хийх - Сургуулиудыг улирал тутам дансны хуулгаар хангах
5. Аймгийн боловсрол, соёлын газар	- Багц тусламжийн төлөвлөлтийг хийхэд сургуулиудад туслалцаа үзүүлэх - Төслийн санал, төлөвлөгөөг хүлээж авч, БСШУЯ-нд мэдэгдэх - Сургуулиудтай гэрээ байгуулах - Багц тусламжийн хэрэгжилтийг хянах/дүрэм журамд нийцүүлэн ажиллах - Сургуулиудаас ирүүлсэн улирлын явцын тайланг хянаж, БСШУЯ-нд тайлагнах - Сургуулиудад туслалцаа үзүүлэх буюу багц тусламжийг зориулалт бусаар хэрэгжүүлж буй сургуулиудад зохих шаардлага тавих - Багц тусламжийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг бэлтгэж, БСШУЯ-д тайлагнах
6. Сургуулийн захиргаа	- Сургуулийн удирдах зөвлөлтэй хамтран төсөл төлөвлөгөө боловсруулах - Төсөл төлөвлөгөө батлагдмагц дүрэм журмын хүрээнд хэрэгжилтийг зохион байгуулах - Бараа үйлчилгээ худалдан авахад сургуулийн удирдах зөвлөлийг татан оролцуулах - Улирлын явцын тайланг сургуулийн удирдах зөвлөлд танилцуулах, сургуулийн зарлалын самбарт улирлын явцын тайланг байршуулах - БСШУЯ, Аймгийн БСГ-т улирал тутам санхүүгийн болон үйл явцын тайланг ирүүлэх - БСШУЯ, Аймгийн БСГ-т санхүүгийн болон үйл явцын хичээлийн жилийн эцсийн тайланг ирүүлэх (хоёрдугаар улирлын тайлан)
7. Сургуулийн удирдах зөвлөл	- Багц тусламжийн төлөвлөлтөд оролцох эрхээ эдлэх - Хэрэгжилт, тайлагнах үйл явцад хяналт тавих (улирал тутмын, жилийн эцсийн тайлан) - Бараа, үйлчилгээг батлах (1 сая төгрөгөөс дээш үнэ өртөг бүхий бараа, үйлчилгээ) - Улиралд нэгээс доошгүй удаа бүрэн бүрэлдэхүүнээрээ хуралдаж байх

үснэгт 8 : Оролцогч талуудын үүргийн хураангуй

Хийх үйл ажиллагаа	БСШУЯ	Төслийн баг	Сангийн яам, төрийн сан	Аймгийн төрийн сан	Аймгийн боловсролын хэлтэс	Сургуулийн удирдлага	Сургуулийн удирдах зөвлөл
Жилийн эхэнд:							
• Багц тусламжийн хуваарилалтыг мэдэгдэх	Х						
• Сонгогдсон аймгуудад олон нийтийг хамарсан кампанит ажил зохион байгуулах		Х					
• Багц тусламжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах						Х	Х
• Багц тусламжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулахад сургуулиудад туслалцаа, арга зүйн зөвлөгөө өгөх					Х		
• Төсөл төлөвлөгөөг хянах (сургуулиуд дүрэм журмын хүрээнд төлөвлөгөөгөө боловсруулсан эсэхийг хянах)	Х	Х			Х		
• Төсөл төлөвлөгөөг батлах явцын талаар тайлагнах (Аймгийн БСГ БСШУЯ-нд)					Х		
• Төсөл төлөвлөгөөг батлах (БСШУЯ)							
Улирал бүрийн эхэнд:							
• Төслийн данснаас мөнгө гаргуулахыг Сангийн Яамнаас хүсэмжлэх	Х						
• Төрийн санд байрших сургуулийн дансанд санхүүжилт хийх			Х	Х			
• Багц тусламжийг хэрэгжүүлэх						Х	
• Хэрэгжүүлэх, худалдан авах, тайлагнах явцад хяналт тавих							Х
Улирал бүрийн эцэст:							
• Аймгийн БСГ-т санхүүгийн болон үйл явцын тайланг улирал тутам ирүүлэх						Х	
• Аймгийн БСГ, сургуулиудад улирал тутам дансны хуулгыг ирүүлэх				Х			
• Дансны үлдэгдлээ шалгаж үзэх						Х	
• Улирлын явцын тайланг хянах – БСШУЯ-нд товч тайлан хүргүүлэх					Х		
• Дараагийн улирлын санхүүжилтийг хийхийг Сангийн яам/төрийн сангаас хүсэмжлэх	Х		Х	Х			
• Жилийн эцсийн тайлан (Сургуулиас Аймгийн БСГ-руу, Аймгийн БСГ-аас БСШУЯ, төслийн багт)					Х	Х	

Хүснэгт 9 : Сургуулийн төсвийн орлого, зарлага

Орлого	Дүн	Зарлага	Дүн
1. Төсвөөс санхүүжих			
1.1 Хувьсах зардал		1. Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	
1.1.1 Хувьсах – цалин хөлс			
1.1.2 Хувьсах бусад зардал		2a. Үйл ажиллагааны бусад зардал *)	
		- Бичиг хэрэг	
		- Шуудан, холбоо:	
		- Дотоод томилолт	
		- Шагнал урамшуулал	
		- Ном, хэвлэл:	
		- Нормын хувцас, зөөлөн эдлэл	
		- Эм	
		- Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	
		- Биеийн тамирын уралдаан, тэмцээн	
		- Эд хогшил худалдан авах	
		- Урсгал засвар	
1.1.3 Багц тусламжийн шилжүүлэг		2b. Багц тусламж	
		- Бичиг хэрэг	
		- Шуудан, холбоо:	
		- Дотоод томилолт	
		- Ном, хэвлэл:	
		- Нормын хувцас, зөөлөн эдлэл	
		- Эм:	
		- Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	
		- Уралдаан тэмцээнд оролцох	
		- Эд хогшил худалдан авах	
		- Урсгал засвар	
1.2 Тогтмол зардал		3. Хэрэглээний зардал	
		3.1 Түлш, халаалт	
		3.2 Гэрэл цахилгаан	
		3.3 Цэвэр, бохир ус	
1.3 Тусгай зорилтот хөтөлбөр		4. Тусгай хөтөлбөр (Шилжүүлэг)	
- Тусгай хөтөлбөр		4.1 Үдийн цай хөтөлбөр	
		4.2 Ном сурах бичиг, бичгийн хэрэгсэл	
2. Өөрийн үйл ажиллагааны орлого			
2.1 Үндсэн үйл ажиллагааны орлого			
2.2 Туслах үйл ажиллагааны орлого			
3. Сайн дурын хандив (Эцэг эх, уул уурхайн компани, бусад)			
4. Орон нутгийн засаг захиргааны хандив, тусламж			
Нийт орлого		Нийт зарлага	

Тайлбар :

- Орлогын 2,3,4 дүгээр зүйл ангид (өөрийн орлого ба сайн дурын хандив) бичигдэх хөрөнгө мөнгийг 'хувьсах бусад зардал' ба үйл ажиллагааны бусад зардалд зарцуулдаг. Харин цалин хөлс, хэрэглээний зардлын тухайд гэвэл орлого зарлага нь тэнцвэртэй байна.
- Багц тусламжийг төсвийн орлогод тусад нь бүртгэж оруулахаар Сангийн Яамтай тохиролцоод байгаа бөгөөд зарлагын хэсэгт нь багц тусламжийн зарцуулалтыг зүйл анги тус бүрээр нь тусгахаар ярилцаж байгаа билээ.

3. Дүгнэлт

3.1 Багц тусламжийн төлөвлөлт

Багц тусламжийн хүрээнд эхний жилд хийгдэх үйл ажиллагааг Хүснэгт 8-д харуулав. 2010 оны дөрөвдүгээр улиралд хийх үйл ажиллагааны санхүүжилтийг хүлээж авахын тулд сургуулиуд 2010 оны 9 сарын 20-ны дотор багтаан багц тусламжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг аймгийн БСГ-т хүргүүлсэн байна.

Аймгийн БСГ-ууд төслийн багийн дэмжлэгтэйгээр төсөл төлөвлөгөөг хянаж, холбогдох дүрэм журмын хүрээнд боловсруулагдсан эсэхэд дүгнэлт өгнө. Дүгнэлтийг хавсралтад тусгасан шалгуурт үндэслэн гаргана (Хавсралт 5).

Бараа, үйлчилгээ худалдан авах болон санхүүжилтийг хийх төлөвлөлтөд үндэслэн санхүүжилтийг нэг жилийн хугацаанд гураваас дээшгүй удаа хийх болно: X/XI, II, IV сард. 2,3 дугаар санхүүжилтийг сургуулиудаас ирүүлсэн хангалттай дүн бүхий тайланд үндэслэн хийнэ. Тийм ч учраас санхүүжилтийг улирал бүрийн эхэнд бус, өмнөх улирлын тайланд үндэслэн дараагийн улирлын хоёрдугаар сард нь хийнэ (тайлагнаагүй сургуульд санхүүжилтийг олгохгүй).

2010/11 оны санхүүжилтийг 2011 оны 6 сарын сүүл гэхэд зарцуулж дуусгасан байна. Сургуулиудын зарцуулаагүй үлдээсэн мөнгийг хоёрдахь буюу 2011/12 оны санхүүжилтээс нь хасаж санхүүжүүлэх болно.

Хүснэгт 9: 2010/2011 оны үйл ажиллагаа

• Сургуулиуд төсөл төлөвлөгөөгөө ирүүлнэ БСШУЯ, төслийн багийн тусламжтайгаар сургуулиудаас ирүүлсэн төсөл төлөвлөгөөг хянах /Аймгийн БСГ/	IX/20-ноос өмнө IX/30-наас өмнө
• Аймгийн БСГ тайлангаа БСШУЯ, төслийн багт хүргүүлнэ	X/1-нээс өмнө
• Эхний санхүүжилтийг олгож эхэлнэ хоног	2010 оны 11 сарын эхний долоо
• Сургуулиуд БСШУЯ, Төрийн сан, сургуулийн удирдах зөвлөлд тайлангаа хүргүүлнэ	I/15 / IV/15-наас өмнө
• Аймгийн БСГ-ууд тайланг хянан үзэж, БСШУЯ, төслийн багт тайлагнана	I/31 / IV/30-наас өмнө
• Дараагийн санхүүжилт	II/V сар
• Сургуулиуд 3 дугаар улирлын ба жилийн эцсийн тайланг хүргүүлнэ Үлдэгдэл мөнгийг сургуулиуд буцаах буюу 2011/12 онд авах санхүүжилтээсээ хасуулан авч үлдэж болно	VI/15-наас өмнө
• Багц тусламжийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, 2011/12 оны багц тусламжинд хамрагдах сургуулиудыг нийтэд зарлах	VIII/15-наас өмнө

3.2 Дараагийн алхмууд

2011 онд гурван аймагт хэрэгжүүлсэн туршилтын төслийг үнэлж, бодлогын шинж чанартай зөвлөмж гаргана. Зөвлөмжинд үндэслэн 2011/2012 оны төслийг нэмэлт 150-200 сургуульд хэрэгжүүлэх бөгөөд сургуулиудыг сонгохдоо аймгийн/сумын ядуурлын төвшин, бүсийн эрх тэгш байдлыг харгалзаж үзнэ. Төсөл хэрэгжих хоёрдугаар жилд төрийн өмчит сургуулийн 40%-ийг, төрийн өмчит сургуульд суралцагсдын 30%-ийг хамруулна.

2011/12 оноос хойшхи хугацаанд сургуулиудыг санхүүжүүлэх тогтолцоог эргэн нягталж, багц тусламжаар санхүүжилт олгоход сургуулийн төлөвлөлтийг хэрхэн хийх, санхүүжилтийг олгоход ядууралд үндэслэсэн аргачлалыг ашиглах эсэх болон сургуулийн удирдах зөвлөлийн үүрэг, ач холбогдлыг дахин авч хэлэлцэж, дүгнэх болно.

ХАВСРАЛТУУД

Хавсралт 1 : Сургуулийн төсөвт багтах зүйл ангиуд

Хавсралт 2 : 2010/11 оны хичээлийн жилд багц тусламжинд хамрагдах сургуулиудад ногдох хувь хэмжээ

Хавсралт 3 : Багц тусламжийг зарцуулах төлөвлөгөө боловсруулах маягт

Хавсралт 4 : Багц тусламжийн хэрэгжилтийн улирлын тайланг бичих удирдамж

Хавсралт 5 : Сургуулийн төлөвлөгөөг үнэлэх шалгуурууд

Хавсралт 6 : Улирлын тайланг үнэлэх шалгуурууд

Хавсралт 7: БСШУЯ-ны Аймгийн БСГ-тай байгуулах гэрээ

Хавсралт 8: Аймгийн БСГ-ын сургуультай байгуулах гэрээ

Хавсралт 1:

Сургуулийн төсөвт багтах зүйл ангиуд

Сургуулийн нэр	20.. онд батлагдсан төсөв Мянган төгрөг
Нийт зардлын дүн	
Үйл ажиллагааны (урсгал) зардал	
Цалин хөлс болон бусад	
Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал	*
Үндсэн цалин	*
Ажил олгогчоос төлөх НДШ	*
Тэтгэвэр, тэтгэмж	*
Тэтгэврийн даатгал	*
Нөхөн төлбөр	*
Үйлдвэрийн ослын даатгал	*
Ажилгүйдлийн даатгал	*
Эрүүл мэндийн даатгал	*
Бараа, үйлчилгээний зардал	
Бичиг хэрэг	*
Гэрэл, цахилгаан	
Түлш, халаалт	
Тээвэр (шатахуун)	*
Шуудан, холбоо	*
Цэвэр, бохир ус	
Дотоод томилолт	*
Ном, хэвлэл авах	*
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	*
Эд хогшил худалдан авах	*
Нормын хувцас, зөөлөн эдлэл	*
Урсгал засвар, тохижилт	*
Төлбөр, хураамж болон бусад	*
Биеийн тамирын уралдаан тэмцээн	*
Дотуур байрны хоол	
Зардлын санхүүжүүлэх эх үүсвэр	
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	
Төсвөөс санхүүжих	
Нийт ажилчдын тоо	
Захиргааны ажилтан :	
Багш :	
Үйлчилгээний ажилтан :	
Сурагчдын тоо :	
Нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж нормативт үндэслэн санхүүждэг зүйл ангийг * тэмдгээр тэмдэглэв	
Эх үүсвэр: БСШУЯ 2009	

Хавсралт 2

2010/2011 оны хичээлийн жилд багц тусламжинд хамрагдах ургуулиудад ногдох санхүүжилтийн хувь хэмжээ

Багц тусламжийн нийт төсөв нь 3.1 сая ам доллар бөгөөд төсөл хэрэгжих эхний жил 80 сургууль, дараагийн жилд 270 (80+190) сургууль хамрагдана гэж үзвэл сургууль тус бүрт 8,850 ам доллар буюу 11,770,500 төгрөг ногдоно (2010 оны 8 сарын 16-ны өдрийн ханшаар).

Сургууль бүрт ногдох багц тусламжийн хувь хэмжээг дэлгэрэнгүй байдлаар дараагийн хүснэгтэд харуулав.

